



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/410

Булган сум

Зөвлөл болон комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Үнэлгээний асуудал хариуцсан комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар, Устгалын асуудал хариуцсан комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар, Худалдан борлуулах асуудал хариуцсан комиссын бүрэлдэхүүнийг 4 дүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох журмын дагуу удирдан зохион байгуулж ажиллахыг зөвлөлийн дарга, Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/434 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
... дугаар сарын ...-ны/ний өдрийн ... дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ШИЙДВЭРЭЭР ХУРААН АВСАН
ХӨРӨНГӨ, ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГСЛИЙГ ҮНЭЛЭХ, ХУДАЛДАН БОРЛУУЛАХ,
УСТГАХ ТАЛААР ШИЙДВЭР ГАРГАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга
	Байгаль орчны газрын дарга
	Татварын газрын дарга
	Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга
	Орон нутгийн өмчийн газрын Өмч хариуцсан ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2025 оны
... дугаар сарын ...-ны/ний өдрийн ... дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн Орлого хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Санхүүгийн хөндлөнгийн шинжээч
Цагдаагийн газрын Эдийн засгийн ахлах мөрдөгч
Статистикийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн
Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Шинжээч


Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 11-ны/ний өдрийн 4/110 дүгээр
захирамжийн 3 дугаар хавсралт

УСТГАЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний
албаны дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав
Албадлагын арга хэмжээ авах шийдвэр гаргасан эрх бүхий
албан тушаалтан
Холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулсан
этгээд (хүсэлт гаргасан тохиолдолд)

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 11-ний өдрийн 414/а дүгээр
захирамжийн 4 дүгээр хавсралт



ХУДАЛДАН БОРЛУУЛАХ АСУУДАЛ ХАРИУЦСАН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний
албаны дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав
Орон нутгийн өмчийн газрын Өмч хариуцсан ахлах
мэргэжилтэн
Албадлагын арга хэмжээ авах шийдвэр гаргасан эрх бүхий
албан тушаалтан (хүсэлт гаргасан тохиолдолд)